

**АЖЛЫН ҮНДСЭН АГУУЛГА:** “Оюун ба сэтгэлийг арга, билгийн зохилдлого хийгээд нэн шинэ философийн үүднээс авч үзэхүй” /“Нийгмийн гэгээрэл ба утга зохиол шинжлэл” / бүтээлийн танилцуулга:

“ЗАГАС БАРИХАД СУРГАХ УХААН”:

НИЙГЭМ-ХҮМҮҮНЛЭГИЙН САЛБАР ДАХЬ  
ШИНЭ ХАНДЛАГА\* /НЕОПАРАДИГМ/ БҮХИЙ  
ОНОЛ - АРГАЗҮЙН ТУУРВИЛ

**Зорилго:** “Оюун ба сэтгэлийг арга, билгийн зохилдлого хийгээд нэн шинэ философийн үүднээс авч үзэхүй” /“Нийгмийн гэгээрэл ба утга зохиол шинжлэл” / бүтээл нь нийгэм, хүмүүнлэгийн тэр дундаа утга зохиол шинжлэлийн салбарын хувьд онолын тогтолцоот мэдлэгийн цөмийг шинэчлэн бүрдүүлэх мета- оролдлого бүхий орчин цагийн онолын сурвалж бичиг болой.

**Судалгааны шинэлэг хандлага /онол - аргазүй/:**<sup>1</sup>

Герменевтик, соёлын парадигм, семиотик, синергетик болон бусад., Тодруулбал, хэлний текстийн байгууламжийн зэрэглэл, бичвэр сүлэлдээн буюу философи, нийгэм, улс төр, эдийн засаг, хууль, түүх, шашин, утга зохиол шинжлэл ба соёл, урлаг, уран сайхны түүхэн текстүүдийн өдгөө цаг дахь харьцууллын арга хийгээд эдгээрийг зүүх, нэгтгэх, дүгнэх, хураах, найруулан товчлох буюу “соёлын семиотикийн” өнгөрсөн соёл ба өнөөдрийг жиших ерөнхий арга., жирийн хар яриа, егөө, шударга чигч доош хийхэд холбогдох үг өгүүлбэр хавчуулах хийгээд хавсарсан дохиолол утга бүтээх, түлхүүр санаа дэвшүүлэн орхих, ярьж буй сэдэв, судлагдахуунд тухайлан холбогдох ишлэлүүдийн зүүвэр чухал ба хэл найруулгын чигжсэн онцлог буюу мэдээллийн дагнасан, цуварсан урсгалтай шинжлэх ухааны академик хэлийг даван гээх нийтэд ойлгомжтой, сонирхолтой, ардчилсан /орчуулах боломж буюу семиотик аргад түшсэн тодорхой, энгийн хэл/, түлхүүр хийгээд нууцлалыг хадгалсан текстүүд., тэдгээрт холбогдох утгыг тайлах аргачлал болох мета онолын аналогий төсөө загвар

<sup>1</sup>\*Эл бүтээл дэх “Нээлт” гэдэг нэр томъёог “Суурь кодочлол” гэдэг нэр томъёотой дүйцүүлэн ойлгож болно (Зохиогч)

\*“Шинэ хандлага” гэдэг нэр томъёо “Эрс шинэ Парадигм” гэдэг нэр томъёотой дүйх (Редактор)

бүтээх, диаграмм, хүснэгт, гаргалгаа хийх зэрэг өнөөгийн танин мэдэхүйн зохих төвшин үйлчилсэн гэсэн үг.

Бүтэц: “Нийгмийн гэгээрэл ба утга зохиол шинжлэл -4 дэвтэр” хэмээх эл эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл нь 4 дэвтэр, 7- 8 бүлэг хийгээд онолын бүхий л сэдэвт хамаарах бүрдцийг төлөөлж буй.

Эл томоохон бүтээлд мета онолын өгүүлэл 7 - 9, онол-шинжлэлийн өгүүлэл 10 – 20, тойм өгүүлэл 15 - 20, хялбаршуулсан өгүүлэл 10 гаруй буй. Диаграмм

/дугуй хүснэгт/ 2-3, хүснэгт /зохиомжийн зүйлсээр/, гаргалгааны бүдүүвч, зураглал /ерөнхий кодочлол/ нийтдээ 10 орчим хэрэгжсэн тооцоо гарна.

Номын дизайн: Ерөнхий бүдүүвч, бүтэц хэсгүүдийг нимгэн цэнхэр цаасаар тусгаарлан зааглаж өгснөөс гадна, дотоод агуулгыг ялгах тэмдэг бүхий дүрс зургаар тодчилж өгсөн. Түүнчлэн түлхүүр нэр томъёо, товчилсон нэрс, зохиогчийн афоризм байрлажээ.

“Нийгмийн гэгээрэл ба утга зохиол шинжлэл -4 дэвтэр” хэмээх уг бүтээлийн ерөнхий гаргалгааны /шинэлэг үзэл баримтлал, тайлан унших аргачлал хийгээд нээлтийн загварчлалд холбогдох/ хэсгээс англи хэл рүү хөрвүүлжээ.

Уг бүтээлийн эхэн ба бүлэг бүрийн эхэнд хэд хэдэн хэсэг хөрөг зураг байрлаж буй. Тухайлбал, зохиогчийн гэрэл зураг уг бүтээлийн эхэнд товч танилцуулгын хамт байрласан. Дэд дэвтрийн өмнө Дэлхийн философи, урлаг, утга зохиол шинжлэлийн суут сэтгэгчдийн хөрөг зургаас тайлбартайгаа буй. Гутгаар дэвтрийн өмнө онолын сэтгэлгээнд зохих хувь нэмэр оруулсан зарим Монголч эрдэмтний гэрэл зураг, тайлбартайгаа байх жишээтэй.

Хавсралт дахь уг бүтээлд төдийгүй хамтын цогцолбор төсөлд өгөгдсөн албан ёсны үнэлгээний хэсэгт Гадаадын хийгээд Монголын судлаач, эрдэмтдийн зургийн цомгоос хамтатган байрлуулсан.

Агуулгын товчоон: Тэргүүн дэвтэрт, нийгэм - хүмүүнлэгийн шинжлэх ухааны нэгтгэгч цөм бүрдүүлэх асуудал нь уран зохиол шинжлэлтэй уялдахын учир, уран зохиолын тухай ерөнхий сургаал, тодорхой зохиолын тухай сургаал, уран зохиолын хөгжлийн тухай сургаал гэсэн гурван зүйлийн тухай онол, эдгээрийн хуульзүйг өнөөгийн философи – танин мэдэхүйн мета төвшинд гүйцэн тодорхойлох, энд холбогдох орчин үеийн үнэлгээ, сургаал, сургалт -

аргазүй, өмнөх туршлага хийгээд өнөө тулгараад буй асуудал, шийдэх боломж, бололцоо, эмх цэгц хайх, орчин үеийн парадигмын бичлэгийн чадвар зайлшгүй чухалчлагдах байдал буюу эл бүтээлийг бичсэн ерөнхий аргазүйг ойлгон ухаарах болно.

Дэд дэвтэрт, оюун ба сэтгэлийг арга, билгийн зохилдлого хийгээд нэн шинэ философийн үүднээс авч үзсэн мета онолын томоохон өгүүлэл хийгээд уран зохиол шинжлэл, түүний салбар, орчин үеийн шинжлэх ухааны арга гэгддэг позитивизм, неопозитивизм ба уран сайхны шүүмжлэл, түүний төрөл хэлбэр, уран зохиолын дүрслэгдэхүүн, уран зохиол ба уран бүтээлч, бичвэр, улс төр, үзэл суртал, түүнчлэн захиалгат уран зохиол, тунхаг, тунхаглал, сэтгэхүй, сэтгэлзүй, гоозүй зэргийг ялган бүлэглэж, нэгтгэн дүгнэх зорилго тавьж, зохих хүрээнд шийджээ.

Гутгаар дэвтэрт, зохиол бүтэж бүрдэх эхний шатны ойлголтыг багцлан хүргэх зорилгоор зөн билиг, онгод, мэдрэмж, авьяас, үүдэл санаа, хоёр дахь шат буюу уран санаа, уран сэтгэмж, ургуулан бодохуй, зохион найруулах зэргийг мөн адил авч үзсэн. Түүнчлэн зохиолын төлөвлөгөө, зохиолын байгууламжийн тухайд хураангуйлж бичжээ. Тодорхой зохиолын тухай онолын асуудал буюу агуулга ба хэлбэр, сэдэв ба утга санаа, зохиолын явдал ба өгүүлэгдэхүүн, эдгээр болон тодорхойлох онол, журамлах онол, төрөл зүйл, уламжлал шинэчлэл, залгамжлал, арга, сэтгэлгээ, чиглэл, урсгал, уран сайхан чанар, эргэх холбоо, сэтгэлгээ, хэл найруулга зэргийн тухайд гаргалгааны бүдүүвч түүнчлэн зохиолын хэлний асуудлыг авч үзэх орчин үеийн зарим үзэл баримтлал хийгээд чимэг үг, зүйрлэл, адилтгал, төлөөлөл, ихэсгэл, өгөөдөл, ёгтлол зэргийн тухайд тодорхойлолтыг харьцуулан жишиж авч үзжээ.

Дөтгөөр дэвтэрт, зохиомж – хэл - дүрийн шүтэлцээ нэрийн дор зарим үзэл баримтлал, шинэлэг судалгааны дүгнэлт хийгээд уламжлалт ойлголтын ялгаа зааг, хөрөг дүр, байгалийн зураглал, тодорхойлол, захидал, зохиолчийн тэмдэглэл, дотоод яриа, үглэл яриа, харилцан яриа болоод эдгээрт тулгуурлан дүрд зохиомж, анализ хийх асуудлыг загвар байдлаар таниулахыг зорьсон. Түүнчлэн хэл–арга– найруулга-сэтгэлгээний барилдлагын асуудлыг бүхэллэг хийгээд цогц бүрдэлд авч үзсэн. Өмнө дэвтэрт дурдсан онолын нэр томьёо, ойлголтыг баримт жишээтэй уялдуулан үзэх ба түүнчлэн дүрслэх хэрэглүүр

болох чимэг үг, зүйрлэл, адилтгал, төлөөлөл, ихэсгэл, егөөдөл, ёгтлол, хэлний илэрхийлэл болсон ойролцоо нэр, эсрэг нэр, давталт, өгүүлбэрзүйн зэрэгцүүлэл, ахиулал, хураангуйлал, тойруулал, яруу асуулт, яруу хандал, яруу дуудал зэргийг мөн хэл - сэтгэлгээний тодорхой баримтад тулгуурлан судалснаар шинэлэг хандлага оршиж буй.

Уран зохиолын тухай ерөнхий сургаал, тодорхой зохиолын тухай сургаал, уран зохиолын хөгжлийн тухай сургаал гэдгээс энэ бүтээлдээ эхний хоёрт аль болох гүйцэт хандах зорилго тавьжээ. Харин сүүлийн хэсгийг зохих байдлаар тусган үзсэн хэдий ч урлаг, уран зохиолын сэтгэлгээний түүхэн хөгжлийн явц, үе шат, урлаг ба уран зохиолын төрөл зүйлийн адил ба ялгаатай тал, үнэт чанар, уран зохиолын чиглэл, урсгал хийгээд арга маяг, бичлэг найруулгын олон дэг сургууль, уран зохиолын төрөл зүйл /уянга, туульс, жүжиг, эссе гэх мэт/, тэдгээрт холбогдох онол – туурвилзүйн түүхэн асуудал, уран зохиолыг судлах орчин үеийн аргазүйн тухайд цаашид хамтын оюун санааны хүрээнд дэлгэрүүлэн авч үзэх зорилго тавьж, орон зайг тооцсон тал буй.<sup>2</sup>

Түүнчлэн нэрсийн хэлхээ, номзүй, ерөнхий гаргалгаа, хавсралт зэрэг нь эрдэм шинжилгээний зохих төвшинд бичигдсэнийг гэрчилнэ.

Гол үр дүн - Нээлт: “Хүний /арга/ нийгмийн /билиг/ хөгжлийн орчин үеийн оновчтой төсөө загвар” /Үзэл баримтлал – Энэ нь Веберийн “Санаан хэв маяг” хэмээх шалгуур үзүүлэлттэй дүйж буй/, “Гурван шулууны огтлолцол буюу гурамсан зангилааны зарчим” /Аргачлал/, “Монгол гэрийн бүрдцийн аналогийн төсөө бүтээх арга буюу уран зохиолын онолын байгууламж” /“Суурь код”/, цаашид “Нээлт”/, “Толгойгүйн дээр хоёр хөлгүй шахуу их биеийн зэрэмдэг онол” буюу “Их биеийн хагас хугасын онол” /Шинэ томьёолол/ зэрэг өнөөгийн шинжлэх ухааны философи гэгддэг неогерменевтик – гоозүй – уран сайхны ертөнцийг танин мэдэх мета онолын төвшин /эпистемологи хийгээд онтологи/ үйлчилсэн гэсэн үг.

Үнэлэлт, мониторинг: “Нийгмийн гэгээрэл ба утга зохиол шинжлэл -4 дэвтэр” хэмээх эл орчин үеийн онол – аргазүйн цогц бүтээлд өгсөн албан ёсны үнэлгээ дүгнэлт гэвэл, Монгол Улсын Оюуны Өмчийн Газар хийгээд Утга

---

<sup>2</sup>\* “Томьёо” гэдэг үгийн бичлэгийг Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын “Монгол үсгийн дүрмийн толь” бүтээлийг барин тогтоов.

зохиолын боловсролын шинэчлэл академи, Боловсролын хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Их дээд сургууль, Боловсрол төвийн багш, заах аргазүйчид буюу эдгээрт хамаарах академич 8-10, шинжлэх ухааны доктор 8 - 10, боловсролын доктор 8 – 10, заах аргазүйч багш нар 5 - 7, түүнчлэн оюутан суралцагсад 80 - 100 орчим буй.

Шинжээч С.Байгалсайхан

/Хэл зохиолын хүрээлэн/

болон бусад.,

Тамга, гарын үсэг бий. /2016 онд сэтгүүлд хэвлэгдсэн/

... ..

Meta – theory is a theory of three eyes of spirit (from Wikipedia )

Meta – theory is a theory of about all things... (Perfect Interpretation)

Meta – theory is a knowledge of about preselected knowledge (from Wikipedia )

Meta – theory is the axiom of degree theorem of truth (from Wikipedia)

New Scientific effective factory book and journal (World brand of Spirit)